



ЖОН ФАЙГЕН

Олон улсын ГХЦГ ба Пестицидийн Холбоо (ИНРА)

КРИСТИАН ЭГЕНХОФЕР

Европын Бодлого Судлалын Төв (CEPS)

ҮХЛИЙН АЮУЛТАЙ ХЭРЭГЛЭЭНЭЭС ХАСАГДСАН ПЕСТИЦИДУУД

Эргэх тоолуур нь ажилласан
тэсрэх бөмбөг ба яагаад бид
одооноос хөдлөх тухай

Colophon
IHPA
c/o Elmevej 14
DK-2840 Holte

- Нэр: Үхлийн аюултай хэрэглээнээс хасагдсан
пестицидүүд,
эргэх тоолуур нь ажилласан тэсрэх бөмбөг ба
яагаад бид одооноос хөдлөх тухай.
- Зохиогчид: Жон Файген, Олон улсын ГХЦГ ба Пестицидийн
холбооны захирал (IHPA), Кристиан
Эгенхофер, Ахлах судлаач, Европын Бодлого
Судлалын Төв, Брюссель, (CEPS)
- Хэвлэлийн газар: Tauw group bv, The Netherlands (on behalf of
IHPA, c/o Elmevej 14, DK-2840 Holte.)
- ISBN-13: 978-90-76098-10-4
- Хэвлэлийн эхийг: Rooduijn communicatie & design, The Hague
- Хянасан: Pieter Vonk, Marketing & Communications dept.,
Tauw bv. Deventer
- Хэвлэлтийг: Marketing & Communications dept., Tauw bv.
Deventer
- Фото зургийг: Matthijs Bouwknegt, Berto Collet, Boudewijn
Fokke
- Нүүрний зургийг: Jan Betlem

2009 © IHPA, Holte

Бүх эрхийг хуулиар хамгаалсан. Зохиогчийн эрхийг эзэмшигч болон
зохиогчийн урдчилан тохирсон бичгэн зөвшөөрлийн дагуу
хуулбарлахыг зөвшөөрнө.

**Хэрэглээнээс хасагдсан
пестицидийн хуримтлал нь зөвхөн
хүн амын эрүүл мэндэд аюул
учруулаад зогсохгүй байгалийн
нөөцийг бохирдуулж нийгэм
эдийн засгийн хөгжилд саад
учруулдаг. Энэ бэрхшээлийг үр
дүнтэй аргаар шийдвэрлэлгүй
хэдий чинээ удна, дараа нь өртөг
зардал нь төдий чинээ их, хүнд
хэцүү байх болно.**

**Данута Хюбнер, Европын Холбооны бүс нутгийн бодлогын
асуудал эрхэлсэн комиссар (Хюбнер, 2007).**



**Хүнсэн дэх нитрофеноос
үүдэлтэйгээр гарсан шууд ба шууд
бус хохирол 500 сая еврогоос
илүү гарсан хэмээн Германы
фермерүүдийн ассоциаци
тооцоолсон байна.**

(Brennpunkt LebensmittelSicherheit, 2002)



Энэхүү чухал асуудлыг шийдвэрлэх хамтарсан арга хэмжээг ойрын үед олон улсын түвшинд шийдвэртэйгээр хэрэгжүүлэлгүй хойшлуулах тусам сүүлд авах арга хэмжээ нь дэндүү оройтсон, дэндүү үр дүн багатай болох болно.

Алемаеху Водагене, Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллагын Хэрэглээнээс хасагдсан пестицидийн асуудлаархи дэлхийн хөтөлбөрийн зохицуулагч асан (Водагене, 2007)



**Хэрэв юу ч эс хийх аваас
хэрэглээнээс хасагдсан
пестицидийн хуримтлалын
ихэнхи хэсэг эрт орой хэзээ
нэгэн цагт хөрс, усанд нэвчиж
улмаар агаар мандалд ялгарна.
Ингэснээр бохирдлыг цэвэрлэх
зардал нэмэгдэж, хордуулах
эрсдэл нь ихсэнэ. Европын
холбоо хэрэглээнээс хасагдсан
пестицидийн асуудлыг
шийдвэрлэх зорилт тавьж
байна.**

Ставрос Димас, Европын Холбооны Хүрээлэн Буй Орчны
асуудал эрхэлсэн түшмэл (Димас, 2007).

ФАЛИЗАН

ВЕНЕЦИАНСКИ ПРАШКАС ЗА СУВИ
КРЕТ-СТРАЖИ



Xn

САРЦА ПРАШКАС



100% ПОВНОСТРАЖИВАЈУЌА

САРЦА ПРАШКАС



Оршил

Бид хэрэглээнээс хасагдсан пестицидийг шийдвэрлэх арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай юм. Хэрэглээнээс хасагдсан пестицид бол маш яаралтай шийдвэрлэх ёстой асуудал мөн. Миний хамтран зүтгэгч Виеслав Кучийн бичсэн Анхаар, Аюултай Химийн бодисууд, хэрэглээнээс хасагдсан пестицидүүд гэсэн номонд орсон миний пестицидийн талаархи өмнөх тайлангаас энд дурдмаар байна.

ХХП-ийн үүсгэж байгаа нөхцөл байдал дордож байгаа тохиолдолд улс төрчид яаралтай арга хэмжээ авч байх тухай тодорхой заасан. Европын Холбооны шинэ орнууд азаар арга хэмжээ авснаар уг асуудал тухайн бүс нутагт ойрын жилүүдэд шийдвэрлэгдэх нь дамжиггүй. Харин энэ асуудал Европын зэрэгцэн орших бодлого баримтлагч орнуудад болон Орос, Төв Азийн улсуудад ямар байна вэ? Бид хүнсний бүтээгдэхүүний асуудлаар шинэ шуугиан гарахыг хүлээж суух уу, эсвэл тэдэнд асуудлаа өөрсдөө шийдвэрлэг гээд харж суух уу.

Би өөрийн тайланд Дани болон Европын Холбооны бусад оронд болсон нитрофений 2002 оны шуугианы үр дагаварын талаар бичсэн билээ. Шинэ аюул нь тэсвэрлэж боломгүй болох ба энэ нь бид урьдчилсан сануулгыг анхаарч үзээгүй болон урьдын туршлагад дүгнэлт хийгээгүйг харуулах болно.

Би уг асуудалд анхаарлаа дараахи хоёр зорилгод төвлөрүүлэхийг онцгойлсон.
 - ХХП-ийн одоо байгаа хуримтлалыг устгах
 - шинэ хуримтлал үүсэхээс сэргийлэх

Эдгээр асуудлыг ХХП-тэй ажиллах олон нийтийн байгууллага эсвэл үүнийг эрхлэх сан байгуулах замаар шийдвэрлэж болох юм. Энэхүү байгууллага нь НҮБ-ын харьяанд байж, Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллагатай (ДХХААБ) нягт хамтран ажиллах талаар би товч тодорхойлсон бөгөөд ХХП-тэй ажиллах талаар НҮБ-ын мандат олгосон байдаг.

Түүнчлэн ДХХААБ -аас Төв Азид санаачлан явуулсан ажил болон 2008 оны 12 сард Азербайжанд зохиогдсон ХХП-ийн талаархи семинартай танилцахыг уриалж байна. Энэхүү семинар дээр нийтлэгдэн гарсан хэрэглээнээс гарсан пестицидийн талаархи шинэ мэдээлэл нь сэтгэл зовоосон мэдээ байлаа.

Энэ нь Европын Холбоо энэ асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэйг харуулж байгаа тул би энэхүү асуудлыг Европын Парламентаас төлөвлөж байгаа хууль тогтоомжид тусгуулахын тулд хүчин чармайлтаа гаргах болно. Ажил хүрээлэн буй орчны байнгын хороонд явагдах ёстой бөгөөд зохих түшмэдүүдийн хоёр талын уулзалтаар дээр дурдсан байгууллага юмуу сан байгуулах тухай тодорхой ажлыг харилцан тохиролцох ёстой.

Европын парламент дах хамтран зүтгэгчиддээ тэдний намын хамаарлыг үл харгалзан энэхүү санаачлагыг дэмжихийг би уриалж байна. ХХП-ийн асуудалд анхаарал хандуулж, зохих шийдвэр гаргахыг маргааш биш өнөөдөр биднээс шаардаж байна.

Дан Ёоргенсен

Европын Парламентийн гишүүн



ДАТИН 2
ТОБЛ-И
ВИН

Өмнөх үг

“Хэрэглээнээс хасагдсан пестицидүүд: Эргэх тоолууртай тэсрэх бөмбөг, бид яагаад одоо хөдлөх ёстой вэ: гэсэн энэхүү тайлан нь хуучин ЗХУ, Өмнөд Балкан болон Европын Холбооны шинэ гишүүн орнуудын ХХП-ийн өсөн нэмэгдэж байгаа аюулын дүн шинжилгээнд бага ч гэсэн хувь нэмрээ оруулах болно. Хэсэг хугацаанд энэхүү асуудалд гүнзгий татагдан орсон болохоор одоохон хөдлөх хэрэгтэй, тэгэхдээ шийдэмгий хөдлөх хэрэгтэй гэж би дахин даван хэлэх байна. Энэ бол миний уриалга бөгөөд үүнийг Европын Комисст хандан уриалж байна. Энэ байгууллага нь уг асуудалд пестицидийн аюулд өртөж байгаа орнуудын хамт оролцож байгаа үндсэн байгууллага юм.

2007 онд би Европын Парламентад олон нийтийн уулзалт ба аюулыг баримтжуулсан үзэсгэлэнг зохион байгуулсан билээ. Үүнээс гадна, үзэсгэлэнг Вашингтонд Дэлхийн Банк/Даян Дэлхийн Байгаль Орчны Сан, Молдав улсын Кишинев хотод зохиогдсон Олон улсын ГХЦГ (гексахлорциклогексан) ба пестицидийн холбооны (ОУГХЦГПХ буюу ИНРА) форум, Вена хотод ЮНИДО (НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага)-ын уулзалт дээр гаргасан болно. Энэ үеэр маш олон санал авсан ба тэдгээр нь ХП хүний организмд үзүүлэх нөлөө, бүтээгдэхүүний аюулгүй байдалд тэдгээрийн учруулах үйлчлэл болон хүрээлэн буй орчинд учруулах хөнөөлийн хэмжээ тасралтгүй нэмэгдсээр байгаад сэтгэл зовж байгаа тухай саналууд байлаа. Энэ бүхэн намайг асуудал шийдэгдэх хүртэл ажиллах хэрэгтэй гэдэгт итгүүлсэн юм.

Би энэхүү үйл ажиллагаанд олон тооны оролцогчдыг татан оруулж, эрчимтэй хүчин чармайлт тавьж байгаад нь Олон Улсын ГХЦГ ба Пестицидийн Холбоонд баяр хүргэхийг хүсэж байна. Энд Европын Комисс, Европын Парламент, ЕХ-ны гишүүн ба Зүүн Европын орнууд, ДХХААБ, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Стокгольмын ба Базелийн конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар, Дэлхийн Банк, Даян Дэлхийн Байгаль Орчны Сан болон бусад төрийн бус байгууллагууд, пестицид үйлдвэрлэгчдийг хамааруулж байна.

Эхний төвшинд бүс нутгийн анхны төслүүд гарч байгаа нь дэвшил юм. ДХХААБ-ын нэрийн өмнөөс ОУГХЦГПХ “ХХПестицид болон Удаан задардаг органик бохирдуулагч пестицидүүдийн чадавхи бий болгох”, Даян Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн хөтөлбөрийн удирдлагын ажлыг Миллеуконтатк Интернэйшнл (Milieucontact), Ногоон Загалмай (Green Cross) болон 9 орны төлөөлөгчидтэй хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажил 2009 оны эхнээс эхэлсэн. Төсөлд мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, чадавхийг бий болгох, бүс нутгийн хамтын ажиллагаа ба туршлага солилцох ажлыг эрчимжүүлэх асуудлууд тусгагдсан. Энэхүү төсөл нь улс орон, мэргэжилтэн нарыг нэгтгэж бүс нутгийн улсуудад цэвэрлэгээ явуулах бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэхэд туслах болно.

ХХП-ийн удирдлагыг хэрэгжүүлэх НҮБ-ын мандаттай учир ДХХААБ нь ХХП-ийн асуудлын судалгааг Төв Ази, Кавказад явуулах ажлыг санаачилсан юм. 2008 оны 12 сарын 2-4-ний өдрүүдэд Азербайжаны Бакуд болсон семинарын үед ДХХААБ-с асуудлын чухлыг тодорхой тэмдэглэж, арга хэмжээ даруй авч хэрэгжүүлэхийг дэлхийн улс орнуудад уриалсан билээ. Сүүлийн үед болж байгаа үйл ажиллагааны хөгжлийг би маш бодитой тооцож, энэ үйл ажиллагааг өргөжүүлэхэд Европын Комиссыг татан оролцуулах чухал боломжийг бий болгож байна гэж үзэж байна. Иймээс би комиссыг ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөө хэлэлцэх дугуй ширээний ярилцлагад оролцон, санал солилцохыг урьж байна.

Виеслав Стефан Куч
Европын Парламентийн гишүүн
2009 оны 4 сар, Брюссель



АГУУЛГА

Оршил	1
Өмнөх үг	3
Ерөнхий тойм	7
1. Танилцуулга	9
2. Олон улсын хэлэлцээрүүд	11
3. Асуудлын түвшин	13
4. ХХПестицидийн цэвэрлэгээний ололт	17
4.1. ЕХ-ны гишүүн орнууд дах үйл ажиллагаа	17
4.2. ЕХ-ны бус орнууд: Багахан ахиц	17
5. Урагшлахад зайлшгүй шаардагдах алхмууд	19
6. Зорилт-үйл ажиллагааны төлөвлөгөө	21
Ишлэл	22
Хавсралт 1. ХХПестицидийн үнэлгээ улс тус бүрээр	25
Хавсралт 2. ЕХ-ны орнуудын үйл ажиллагааны жишээ	27
Хавсралт 3. Товчилсон үгийн тайлбар	28



Ерөнхий тойм

Зориулалтын дагуу хэрэглэх боломжгүй болсон, хүрээлэн буй орчинд удаан хугацаагаар сөрөг нөлөө үзүүлдэг буюу хэрэглээний хугацаа хэтэрсэн, чанар нь муудсан ба тухайн үед хэрэглээний зориулалт нь өөрчлөгдсөн пестицидүүдыг хэрэглээнээс хасагдсанд тооцдог. Энэ тухай Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцоор мэдэгдсэн бөгөөд үүнийг Европын Холбооны гишүүн орнуудын олонхи хүлээн соёрхон баталсан ба Төв болон Зүүн Европын орнууд, хуучин ЗХУ-ын зарим улсууд зөвшөөрсөн билээ. Энэхүү конвенци нь 2004 онд хүчин төгөлдөр болсон юм.

Гишүүн орнуудтай хамтран боловсруулсан Конвенци, түүнийг хэрэгжүүлэх Үндэсний Хөтөлбөрт ЕХ-ны хүрээнд асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх тухай тусгасан болно. Европын Холбооны ХХПестицид, тэдгээрийн хуримтлал ба устгалыг аюултай ХХП-тэй ажиллах тухай Европын Холбооны хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэхийг үйлдвэрлэгчид хэрэгжүүлж байна. Энэхүү ажиллагааг Европын Холбооны зарим гишүүн орнуудад батлагдсан Төв болон Зүүн Европын орнуудад үзүүлэх тусламжийн хөтөлбөр (ТЗЕОТХ (PHARE)) болон үндэсний хөтөлбөр зэрэг Европын Холбооны хөтөлбөрүүдээр хүч нэмэгдүүлсэн байна.

Гэвч зөвхөн Стокгольмын Конвенцийн шаардлагыг хэрэгжүүлэх нь ХХП-ийн эрсдлийг эрчимтэй арилгахад хангалтгүй юм. Конвенцид зөвхөн өвөрмөц 9 пестицидийн талаар заасан бөгөөд (энд болон цаашид удаан задардаг органик бохирдуулагч буюу УЗОБ пестицид гэж нэрлэгдэх) эдгээр нь ХХП-ийн өчүүхэн хэсэг нь билээ. Нэмж хэлэхэд, ялангуяа газар зүйн хувьд ойр орших Зүүн Европ ба хуучин ЗХУ-ын бүрэлдхүүнд байсан орнуудад уг асуудал онц ноцтой хэвээр байсаар байна.

Өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулахгүй бол маш том эрсдэлтэй тулгарах болно. Хамгаалалтгүй агуулахуудын тоо хэдэн арван мянгад хүрээд байгаа нь хоол хүнс, байгаль орчин, амьд организмд үхлийн заналхийлэл болж байна. ХХП нь Европын Холбооны ба гишүүн бус орнууд, хуучин ЗХУ-ын хооронд явагддаг хөдөө аж ахуйн худалдаанд эрсдэл учруулахаар байна. Германд 2002 онд болсон нитрофенээс үүдсэн хүнсний шуугиан шууд ба шууд бус хохирол нь дангаараа 500 сая еврогоос давсан байна. Учир нь хуримтлагдсан пестицидийн агуулахууд голын эргийн дагуу байрлалтай байсанд оршино. Үүний дүнд хорт бодисууд голын усанд орж болох ба ялангуяа, 2002 онд ХБНГУ, Румын, 2008 онд Украин, Молдав болсон үерүүдийн үед онц аюултай болох байсан юм.

Хэдийгээр ХХП-ийн цэвэрлэгээний өртөг харьцангуй хямд ч тонн нь 3,000 евро орчим байна. Европын Холбооны шинэ гишүүн орнууд, ОХУ, Төв Азийн ба Европын Холбоонд элсэхээр төлөвлөж байгаа орнууд, Европын Холбооны хөршийн орнуудад нөөцийн хэмжээ 256,000-263,500 тонн гэж үзвэл түүнийг цэвэрлэхэд 770-790 сая евро шаардлагатай болно.

Зарим орон тодорхой алхам хийхэд бэлэн байна. Молдав улс Дэлхийн Банкны тусламжаар 1,150 тонн УЗОБ пестицидийг устгажээ. Украин улс ХХП 1,000 тонн пестицидийг устгахаар ХБНГУ-д гаргах, цаашид дахин 2,000 тонныг гаргахаар төлөвлөж байна.

Устгалын явцыг цаашид хурдасгахад Европын Холбооны санхүүгийн болон техникийн тусламж шаардлагатай байна. Ингэснээр техникийн мэдээлэлээр хангаж, мэдлэгийн түвшинг нэмэгдүүлж, дунд хугацааны дотоодын санхүүжилтыг хуримтлуулж, тухайн улс орны хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх боломжтой болно.

Бид Европын Комиссын удирдлагыг өөрийн гарт авч, ЕХ-ны гишүүн орнууд, Европын Парламент, ЕХ-ны бус орнуудтай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гаргахыг уриалж байна. Жишээлбэл, Евро-Азийн орнууд, ДХХААБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Дэлхийн Банк, ДДБОС, ТББ, хэрэглэгчдийн байгууллагууд, аж үйлдвэр, химийн үйлдвэрлэлийн хамт, хүнсний худалдаачид дараах зүйлүүдийг гүйцэтгэх шаардлагатай болж байна.

- Ерөнхийлөгчдөөр удирдуулсан Зөвлөл ХХП-ийн асуудлыг дэвшүүлэн, Олон улсын экологийн асуудал эрхлэх зөвлөлийн ажлын хэсэгт тавих ёстой.

- Европын парламент нь:

- ХХП-ийн хуримтлалын асуудлыг Европ дахь хөршийн болон хамтын ажиллагааны төлөвлөгдөж байгаа стратегт тусгах
- Пестицидийн стратегид ХП-ын талаархи зайлшгүй шаардлагыг тусгахыг шаардах

- ХХП-ийн хуримтлалтай орнууд:

- Хүрээлэн буй орчны талаархи өөрсдийн төлөвлөгөөнд тэдгээрийн устгалын асуудлыг чухалчлан тусгах
- Ивээн тэтгэгчидтэй хэлэлцэж, тэдгээрийг устгах тухай асуудлыг нэмэх ба
- Санхүүжүүлэх үндэсний хөрөнгийг олох

- Европын Комисс, Европын Парламент ба ЕХ-ны гишүүн орнууд асуудлын зэрэглэл ба яаралтай байдлын талаархи харилцан ярилцаж, энэ асуудлаар гаргах боломжит шийдлийг сайжруулах

- ЕХ-ны шинэ гишүүн орнууд ХХП-ийн хадгалалт, пестицидийн агуулахын чанар зэргийн талаар тавигдаж буй шаардлагыг яаралтай хэрэгжүүлж, эхлэх асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах

Ургамал хамгааллын ассоциаци нь Бүх Үндэсний болон Олон улсын бодлого боловсруулагчидтай хамтран “Хоосон контейнерийн хөтөлбөр” бий болгох, ХП-г цуглуулж устгах ажлыг Франц, Польш улсуудын жишээгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1. Танилцуулга

Пестицидыг цаашид хэрэглэх шаардлагагүй болсон тохиолдолд хэрэглээнээс хасдаг. Тэдгээрийг хүрээлэн буй орчинд удаан хугацааны үйлчлэл үзүүлдэг, эсвэл үйлдвэрлэгдээд удсан болон муудсан, тухайн үед хэрэглээний зориулалт нь өөрчлөгдсөн тохиолдолд хэрэглэхийг хориглогддог. Иймд, ХХП-ийн асуудал нь пестицидийн хэрэглээтэй холбоогүй юм. Ер нь энэ асуудал ашиглагдаагүй пестицидтэй холбоотой тул тэдгээр нь хэрэглээнээс гарсанд тооцогддог болно. Пестицидын буруу хэрэглээ ба хадгалалттай холбоотой тул уг асуудал дараах зүйлүүдэд хамаарна:

- Нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчны чанар
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа

Асуудал бүр 1950-60 аад оноос тэр үеийн коммунист орнуудад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлэх зорилгоор пестицидийн хэрэглээг нэмэгдүүлснээр эхэлсэн юм. Пестицидийг фермерүүдэд үнэгүй тараан өгч байсан нь хэрэглээ нь хэт их болох, үлдэгдэл ба савыг буруу ашиглахад хүргэжээ. Орчин үед зарим үнэлгээнээс үзэхэд хуучин ЗХУ-ын бүрэлдхүүнд байсан улсууд, өмнөд Балкан, ЕХ-ны шинэ гишүүн орнуудын олон арван мянган агуулахад ойролцоогоор 260,000 тонн ХХП хадгалагдаж байгаа нь Польшоос Киргизстан хүртэлх уудам нутгийг хамарч байна. (Федоров & Яблоков, 2004 ба Хавсралт 1 харах)¹.

¹ Анхаар, Аюултай Химийн Бодисууд, ХХПестицидүүд (Куч, 2007), Зөвлөлийн Ерөнхийлөгч Жосе Мануэл Барросо (Барросо, 2007), 4 комиссар (Димас, 2007; Хюбнер, 2007; Кипрянов, 2007; Мишель 2007); Европын Парламентийн 9 гишүүн, мөн ХХПестицидийг агуулах 5 улсын сайдууд зэрэг бүрэлдэхүүнтэй 45 зохиогчид.



2. Олон улсын хэлэлцээрүүд

Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, устгах тухай Конвенци, 1979 оны НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЕЭЗК (UNECE))-ийн Хол зайд тархах агаарын бохирдлын тухай Конвенци (УЗОБ-ын тухай 1998 оны протокол) болон 1998 оны Зарим аюултай химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенцид химийн тодорхой хорт бодисуудын хор хөнөөлийн тухай мэдээлсэн байдаг.

Олон улсын үндсэн хэлэлцээр нь Стокгольмын Конвенц² бөгөөд энэ нь 152 оронд зөвшөөрөгдөж, 2004 онд хүчин төгөлдөр болсон юм. Одоогоор Орос, АНУ, Турк, Босни Герцеговин, Монтенегро, Серби болон Европын Холбооны Итали, Ирланд, Мальта зэрэг улсууд үүнд нэгдээгүй байна.

Стокгольмын конвенц нь зөвхөн УЗОБ-ын жагсаалтад байгаа тодорхой бодисуудын хэрэглээг хориглосон ба ХП-ийн асуудлыг үндсэндээ хөндөөгүй болно.

Конвенцийн үндсэн уриалга нь:

- заагдсан бодисуудын үйлдвэрлэл ба хэрэглээг хориглох
- импортыг хатуу хориглох
- хуримтлалыг илрүүлж, аюулгүйжүүлэх менежмент
- хөгжиж буй болон шилжилтийн үедээ яваа орнуудын хэрэгцээг хүлээн зөвшөөрөх, техникийн тусламж болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Конвенцийн зорилгыг биелүүлэхийн тулд үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө гаргах асуудлууд болно.

Европын Холбоо Стокгольмын Конвенцийн заалтуудыг Холбооны Хуульд оруулсан ба түүний шаардлагууд нь Европын Холбооны орнуудын болон Европын Холбооны засаг захиргаанд заавал мөрдөгдөх ёстой (УЗОБ-ын тухай Европын Холбооны Үндэсний хөтөлбөр (УЗОБЕХҮХ) (НҮБЕЭЗК, Хэсэг 2.4)).

УЗОБ-ын бүх хаягдлыг аюултай хэмээн үзэж, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг үйлдвэрийн ажиллагаанаас үүсэх гаж нөлөөнөөс хамгаалах, хил дамжих тээвэр, аюултай болон бусад хаягдлыг устгахад Базелийн Конвенци чиглэгдсэн байдаг.³

УЗОБ-ын талаархи НҮБЕЭЗК -ийн протокол⁴ арай өөр чиглэлтэй байдаг. Түүнд 11 пестицидэд хамаарах 16 бодис, 2 төрлийн үйлдвэрлэлийн химийн бодис, химийн үйлдвэрлэлээс гардаг 3 төрлийн дайвар бүтээгдэхүүнийг хамарсан жагсаалт орно. Протоколуудын зорилго нь УЗОБ-ын ямар нэгэн алдагдал юмуу ХХП гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино. Зарим бодисуудын (алдрин, хлордан, хлордекон, диелдрин, эндрин, гексабромобифенил, мирекс, ба токсафен) үйлдвэрлэл ба хэрэглээг шууд хориглосон байдаг. Бусад (Ди-хлор-Дифенил-Трихлорэтан (ДДТ), гептахлор, гексахлор-бензин (НСВ), мөн полихлортбифенил (PCBs)) зэргийг дараагийн ээлжинд хэрэглээнээс хасна. ЮНЕКЕ-ийн УЗОБ-ын протоколд ДДТ, гексахлорциклогексан (НСН) (Линданыг оролцуулан) ба ПХБ-ийн хэрэглээг хатуу хориглодог болно.

² Тогтвортой Органик Бохирдуулагчийн талаархи Стокгольмын Конвенци бол хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг байгаль удаан хугацаагаанд задардаг бөгөөд газар зүйн хувьд өргөн тархацтай, хүн ба амьтны өөхлөг эдэд хуримтлагддаг химийн бодисуудаас хамгаалах тухай олон улсын хэлэлцээр юм. (<http://chm.pops.int/>) -г харах

³ 1989 онд засварлаж, 1992 онд мөрдөөгдөж эхэлсэн (<http://www.basel.int/>) -г харах

⁴ ЮНЕКЕ-ийн Конвенцийн дагуу хил дамнан агаарын бохирдлын талаархи баримт бичиг (CLRTAP) 1998 оны 6-р сарын 24-нд Гүйцэтгэх Зөвлөлөөс Данийн Аархуст баталсан. (http://www.unepce.org/env/ltap/pops_h1.htm).

⁵ Конвенци 2004 оны 2-р сарын 24-нд хүчин төгөлдөр болсон. (<http://www.pic.int/>) -г харах

Эцэст нь Роттердамын Конвенцид⁵ нь тодорхой тооны химийн хорт бодисуудын олон улсын худалдаанд оролцогч талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг юм. Энэ нь талууд хоорондоо химийн бодисын талаархи мэдээлэл солилцох тухай агуулсан болно. Энэ нь эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулагч химийн бодисуудад хамаатай бөгөөд түүний хэрэглээ нь хориглогдсон буюу хязгаарлагдсан байдаг. Одоо Конвенцид 24 пестицидийг оролцуулан 39 химийн бодис, пестицидийн маш хортой 4 хэлбэр агуулсан үйлдвэрийн 11 химийн бодисууд нэрлэгдэн заагдсан юм. ЕХ-нд ХХП-ийг № 850/2004 хуулийн хүрээнд зохицуулж байна. Энэхүү журам нь Стокгольмын конвенци, УЗОБ-ын талаархи НҮБЕЭЗК -ийн протоколд тусгасан зорилготойгоор үйлдвэрлэх 13 УЗОБ бодисын хэрэглээ, үйлдвэрлэл, худалдааг хориглосон олон улсын УЗОБ-ын тухай гэрээний заалт бүхий ЕХ-ны хуулиудад нэгдэж байгаа юм. Энэхүү журам нь ЕХ-ны гишүүн орнуудад диоксин ба фуран төрлийн бодисууд, ПХБ, полиароматик гидрокарбонь (РАН) үйлдвэрлэлийн талаар өргөн утгатай протокол гарган дэмжих ба эдгээр химийн бодисын үйлдвэрлэлийг бууруулахыг үүрэг болгосон байна. Европын Комисс тухайн асуудлын дэвшлийг энэ талаархи үндэсний дэвшлийн тайлангаар нь дүгнэдэг. Уг журам олон улсын гэрээнээс хальж олон улсын хэмжээнд үйлдвэрлэл, хэрэглээг нь хориглосон УЗОБ-ын асуудлыг онцгойлон тусгасан байна. Нэмж хэлэхэд, НҮБЕЭЗК -ийн протокол болон Стокгольмын Конвенцийн зорилго нь гишүүн орнуудын бодлого, хөтөлбөрт яваандаа тусгагджээ.

Стокгольмын Конвенцид оролцогч тал бүр конвенцид тусгагдсан УЗОБ-ын эсрэг тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаа үзүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах ёстой. Европын бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөө 2007 оны 3 сарын 9-д өөрчлөгдсөн юм (Европын Комисс, 2007).

УЗОБЕХҮХ-ний зорилго нь зөвхөн Стокгольмын Конвенцийн хуулийн шаардлагыг биелүүлэх явдал бус, мөн Стокгольмын Конвенци болон НҮБЕЭЗК -ийн протоколд тусгагдсан УЗОБ-ын талаар бүлгийн зүгээс хийсэн ажлын тооцоо гаргах, цаашид хийх үйл ажиллагааны стратеги ба төлөвлөгөө бэлтгэх явдал юм.

УЗОБЕХҮХ-ийн зорилго нь:

- Тухайн үед бүлгээс УЗОБ-ийн талаар явуулж байгаа үйл ажиллагааг тодорхойлох
- Стокгольмын Конвенцийн шаардлагын биелэлтийн үр дүн, түүний хангалттай эсэхийг үнэлэх
- Бүлгийн төвшинд цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны шаардагдах зүйлүүдийг тодорхойлох
- Цаашид зайлшгүй шаардлагатай нэмэгдэл ажлуудыг тодорхойлон тогтоох
- УЗОБ-ын талаархи арга хэмжээ болон хүрээлэн буй орчны юмуу бусад салбарын боломжит харьцааг илрүүлж түүний холбоо хоорондын арга хэмжээний зохицлыг хүчтэй болгох
- УЗОБ-ын талаархи мэдээлэл ба тэдгээрийн хяналтыг нэмэгдүүлэх

ЕХ-нд нэгдээгүй орнуудад ХХП-ийг бүртгэх ба устгахад үзүүлэх тусламжийг ТЗЕОТХ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг. Цэвэрлэгээнд зориулагдсан нэмэлт боломжийг ХП-д зориулан олгоходоо Европын хөршийн бодлогын хүрээнд ЕХ ба хамтрагч бүрийн хоорондын хоёр талын гэрээ байгуулсан нөхцөлд гүйцэтгэнэ.

3. Аюулын түвшин

Пестицидийн хэмжээг нарийн зөв тооцоход маш бэрхшээлтэй. Эдгээр бодисын нилээд хэсэг нь хуучирсан, зохих бичиг баримтгүй байдаг. ГХЦГ-ы томоохон хаягдлууд тодорхой байх ба Стокгольмийн Конвенциор хүлээн зөвшөөрөгдсөн юм. Зарим орнууд шаардлагын дагуу 9 төрлийн хорт бодисын талаархи мэдээлэл цуглуулах шатанд байна. Гэвч энэ нь тохиолдлын бус ба бага нөөцөд хамаарагдахгүй юм. Ялангуяа Стокгольмын конвенцид орсон ХХП-ын нөөцийн үнэлгээ, жишээлбэл, Линдан ба ГХЦГ-ы нөөц ямар байгаа нь тодорхойгүй бөгөөд ойролцоогоор үнэлсэн байж болох юм. 2000 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (2000)-ийн хийсэн үнэлгээгээр Африк ба Ойрхи Дорнодод ХХП-ийн дөнгөж 30 хувь нь УЗОБ байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд ХХП-ийн хэмжээ УЗОБ-оос 3 дахин их байна.

ХХП-ийн нөөцийн хэмжээний тухай мэдээг нөөцийн тоолллогын явцад зарим агуулах, ХХП шинж чанар, тоо хэмжээний шалгалтыг оролцуулан гаргадаг. Пестицидийн холбооны дүгнэлтээр ЕХ-ны зарим орнууд дахь /хуучин гишүүн орнуудаас гадна /ХХП-ийн хэмжээ 256,000-263,500 тонн/хавсрат 1-ийг үз/-д хүрч болзошгүй ба ЕХ-ны шинэ орнууд, Европын хөршийн бодлогод нэгдсэн орнууд, ОХУ ба Төв Азийн орнууд энд хамаарах ажээ.

Хүснэгт 1. Бүс нутгууд дах ХП-ийн хэмжээний тооцоо

Бүс нутаг	Үнэлэгдсэн бодис,тонн	Үнэлгээ /сая евро/
Европын Хөршийн Бодлогын орнууд ба ОХУ	151,500	454.5
Төв Ази	47,500	142.5
ЕХ-д нэгдэхийг төлөвлөж буй орнууд	36,000-41,5000	108-124.5
ЕХ-ны шинэ гишүүн орнууд	21,000-23,000	63-69
Бүгд	256,000-263,500	768-790.5

* Устгагдсан ба аюулгүй хадгалагдаж байгаа бодисын тонн тус бүрийг 3000 еврогоор тооцов.

Эх сурвалж: ОУГХЦГПХ, УЗОБ-ын Конвенцийг биелүүлэх Үндэсний хөтөлбөрүүд.

(1-р хавсралтыг үз. 1-р хавсралтад бутархайг шилжүүлснээс бага зэрэг зөрөө гарсан болно)

Эдгээр хуримтлал дараахи хүндсэн 4 хэлбэрээр оршино:

- Хэдэн арван килограммаас хэдэн арав, зуун тонн хүртэлх бага хэмжээгээр тоологдох хуучин агуулах эсвэл түүний эргэн тойронд орших нөөц ба тэдгээрийг үлдэгдэл (зарим газарт 1000 хүртэлх тонн). Эдгээр нь хэдэн арван мянган газарт тархсан байна.

- Хуучин ЗХУ-д байрлах полигон гэж нэрлэх тодорхой газарт байх нөөц. Энэ нь хуучирсан пестицид болон бусад хорт бодисыг аюулгүйгээр хадгалахаар төлөвлөж байгуулсан тусгай талбарууд болно. Эдгээр талбарууд гол төлөв сайтар тоноглогдсон, харуул манаатай байсан ба тооцоог нарийн хийдэг байжээ. Гэвч ЗХУ-ын хяналтын төвлөрсөн систем задран унаснаар устгалын газруудад орхигдон харуул хяналтгүй болж, пестицидийг хууль бусаар ухан гаргаж, дахин савлаж орон нутгийн зах зээлд буюу зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүд гадаадад гарган худалдаалсан байна. Устгалын

газрууд нь концепцийн дагуу хязгаарлагдмал тооны маш том талбарууд байх ба заримдаа тэдгээр нь бусад хорт бодистой хамт хадгалагдсан байдаг.

- Пестицидийн үйлдвэрлэлийн үед үүссэн хаягдлууд. Үүний үндсэн хэсэг нь ГХЦГ бөгөөд Линдан үйлдвэрлэхэд үүснэ (Файген, 2006). ГХЦГ⁶-ы ХХП цөөн хэдэн талбайд хаягдсан байх ба хэдэн арваас хэдэн зуун мянган тонн, түүнээс ч их хэмжээтэйгээр байдаг байна.

- Перхлорэтилений (тетрахлорэтан, PER, PERC гэж ч нэрлэгддэг), карбонаттетрахлорид, трихлорэтилений үйлдвэрлэлийн дагавар бүтээгдэхүүний ХХП ба пестицид болгон ашигладаг гексахлорбензиний (НСВ) ХХП. НСВ-ийн хамгийн их нөөцийг Чех (Хайниш 2006 ба 2007, Холоубек 2006) болон Украин улсуудаас олж болно (нэмэлт 3-аас харах).

Бүх ХП-ийн цэвэрлэгээний үнэ харьцангуй хямд байна. ОУГХЦГПХ-ийн хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнгээс үзэхэд ХП-ийн цэвэрлэгээ, дахин савлалт, тээвэрлэлт болон бүрэн устгалын үнэ тонн тутам 3,000 евро болно. ДХХААБ-ынх үүнтэй ойролцоо байна. Эдгээр зардлууд Африкт тонн тутамд 3,000-5,000 ам. доллар байгаа юм. ОУГХЦГПХ-ийн тооцоонд үндэслэвэл Европын хөршийн орнууд, ЕХ, ЕХ-д нэгдэхээр зэхэж буй орнууд, Орос, Төв Азийн орнуудад 770-790 еврогийн өртөгтэй болохоор байна. ДХХААБ-ын тооцоогоор энэ зардал арай их болох юм.

Идэвхгүйжүүлэлтийн үнэ цэвэрлэгээнийхээс арай өндөр болно. Европын Экологийн байгууллагын тайланд зааснаар идэвхгүйжүүлэлтийн үнийг бууруулах нь байнга яригддаг асуудал болно (Коппе, Кейс, 2001).

⁶Техникийн ГХЦГ буюу гексахлорциклогексан нь 1948 оны орчим хэрэглээнд гарсан анхны бүтээгдэхүүн юм. Түүний хүчтэй, муухай үнэр нь бүтээгдэхүүнд шингэдэг тул таримал ургамалд хэрэглэхэд үндсэндээ ашиггүй байсан тул техникийн ГХЦГ-ийн хэрэглээ аажимдаа багасч, түүнийг Линданаар сольсон билээ. Линданы үйлдвэрлэлтийн үед үүсэн хажуугийн бүтээгдэхүүнээс гардаг ГХЦГ-ийн изомерүүд нь техникийн ГХЦГ дэлхийд хамгийн өргөн хэрэглэгддэг пестицид болохын хувьд чухал бодис болно. Үйлдвэрлэгдсэн тонн линдан бүрт 8-10 тонн ГХЦГ гардаг. Ли-ийн үнэлснээр /1999/ техникийн ГХЦГ-ийн хэрэглээ 1948-1997 онд 10 шахам сая тонн болсон бөгөөд энэ нь түүхэнд бусад пестицидээс хамгийн ихээр хэрэглэгдсэн пестицид болж байна. /Файген, 2006/

ХХП-ын нөгөө гол асуудал нь Линдан ба ГХЦГ-ийн хаягдлын альфа, бета изомерүүд юм. Эдгээр нь адил шинж чанартай боловч УЗОБ-ын ангилалд ордоггүй. Нэгдлүүдийн эрсдэл ба хэмжээнээс болж ХХП-ын асуудал эрхлэх комисс болох Стокгольмын Конвенцийн байгууллага химийн бодисын жагсаалтыг Конвенцид оруулах талаар талуудаас гаргасан саналыг хараалзан зөвлөмжийг гаргасан билээ. Эдгээр химийн бодис нь УЗОБ-д бүртгэгдэх эсэх асуудлыг 2009 оны 5-р сард болох талуудын 4-р конвенцоор шийдэх байх гэж хүлээгдэж байна.

Нэмэлт 1. Идэвхгүйжүүлэлтийн үнэ

Хуучин зүүн Германы нутагт 2002 онд Герман, ЕХ хоёр нитрофений органик бүтээгдэхүүний бохирдлын үр дагавартай тулгарав. Бүтээгдэхүүн пестицидийн хуучин агуулахад хадгалагдаж байв. Агуулахын хөрс бохирдсон байснаас хадгалагдаж байсан бүтээгдэхүүн мөн бохирдсон байжээ. Германы фермерүүдийн ассоциаци 2002 онд нитрофений асуудлаас болж гарсан шууд ба шууд бус алдагдал 500 сая гаруй евро болсныг тооцсон байна.

Эх үүсвэр: Brennpunkt LebensmittelSicherheit (2002).

Нэмэлт 2. Идэвхгүйжүүлэлтийн эрсдэл

Эдийн засгийн реформын асуудал эрхлэх Германы зөвлөлдөх хэсэг 2002 онд “Баруунд хориглогдсон зарим хөдөө аж ахуйн химийн бодисууд ЗХУ-д хэрэглэгдсээр байгаа ба дараа нь Украинд хэрэглэгдэж байж болох юм. Эдгээр химийн бодисууд техникийн хувьд төгс бус байсан /байгаа/ байх гэж үзэж болох юм. Иймд бүтээгдэхүүний бохирдлын талаархи асуудал Германд гарсан нитрофенийх шиг мөн Украинд гарахыг үгүйсгэж болохгүй. Хүнсний үйлдвэрлэлийн төлөөлөгчид анхааруулахдаа Украины бүтээгдэхүүний аюулгүй байдал нь эргэх тоолуур нь залгагдсан тэсрэх бөмбөг” гэж нэрлэсэн байна.

Эх үүсвэр: Cramon-Taubadel, S. von (2002).

Украинд 13,000 орчим агуулах байгаа гэж үзэж байгаа ба тэдгээр нь ОП-р бохирдсон буюу бохирдох шатанд байгаа гэж үзэж байна. Украины засаг захиргааны тооцооноор 5,000 газарт 32,000 орчим тонн нөөц байна. Олонхи талбарт нь хүн амьтан хүрэх бололцоотой тул ойролцоо байдаг хүмүүст, ялангуяа, хүүхэд гэрийн тэжээмэл амьтдад аюул учруулж болзошгүй байна. Агуулахууд нь гол төлөв орон нутагт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд ойр байдаг нь үлдэгдэл бодисууд хөрс, усанд орж, усны нөөцөд аюул учруулж болзошгүй байгаа ажээ.

Эх үүсвэр: Antonov & Gamera (2007).

Нэмэлт 3. ГХЦГ нь Баруун Украины Иванофранковск мужийн Калуш дахь эргэх тоолуур нь залгагдсан аюултай тэсрэх бөмбөг

Украинаас Молдав руу урсдаг Днестр мөрний цутгалан Савка голын эрэг дагуу Европт хамгийн том ГХЦГ-ын агуулахууд оршиж байна. Днестр мөрний савд 7 сая орчим хүн амьдардаг ба уг мөрний ус нь Молдав улс, Украины зарим хэсгийн ундны ус болдог ажээ. Эдгээр агуулахууд УЗОБ-аас цэвэрлэгдэх ёстой онцгой агуулахууд бөгөөд тэдгээрт байгаа хэдэн арван мянган тонн НСВ-г даруй устгах шаардлагатай байна. Тооцоогоор энэхүү талбарт Украины ОП-ын 30% нь байгаа ажээ. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөгөөр (засаг захиргаанаас 2006 онд батлах) уг агуулахыг устгахаар заажээ. Гэвч ажлын төлөвлөгөө батлагдаагүй тул ямар ч ажил хийгдээгүй байна.

Эх үүсвэр: Environment and security, 2007; UNECE, 2004; National Environmental Policy of Ukraine 2007; Antonov & Gamera (2007); CLU-IN, 2008



4. ХХПестицидийн цэвэрлэгээний ололт

4.1. ЕХ-ны гишүүн орнуудын үйл ажиллагаа

ХХПестицидийн асуудал бол ЕХ-ны бүх улсуудад өргөн яригдах асуудал юм. Ашиглагдаагүй болон хуучирсан бүтээгдэхүүнийг “Илгээгчидэд нь буцаах” ажиллагаа ЕХ-ны хувьд байнга хийгдэх ажил бөгөөд ингэснээр ХХП-ын агуулах хаана хамаарагдах нь тодорхой болно. ЕХ-ны хуулиар үйлдвэрлэгчид ХХП-тэй холбоотой бүх асуудал, үүний хамт цуглуулах ба устгах асуудлыг шийдвэрлэж байх ёстой юм. ЕХ өргөжсөнөөр уг хуулийн үйлчлэл шинэ улсуудад хүрэх болсон юм. Шинэ улсууд ЕХ-нд нэгдсэний дараа шилжилтийн үедээ PHARE ба DANCEE (Данийн байгаль орчны Зүүн Европт туслах хөтөлбөр)⁷ сангийн адил хөтөлбөр гаргаж, Төв ба Зүүн Европын 8 шинэ оронд асуудлыг шийдвэрлэхэд нь тусалсан байна. /хавсралт 2-г үз/. Жишээ нь, Нитрофений шуугианы дараа 2002 онд /нэмэлт 1-г үз/ Европын Комисс /Байгаль орчны асуудлаарх Ерөнхий Захирлын Зөвлөл/ гишүүнд элсэх орнууд дах ХХП пестицидийн байдлын тухай тайланг нийтлэн гаргав /Европын комисс 2002 он/. Тайланд гишүүнээр элсэх 30 орон хамрагдсан бөгөөд тэдгээр нь 2004 онд элссэн бөгөөд энд Чех, Кипр, Эстони, Литва, Латви, Мальт, Польш, Унгар, Словак, Словени улсууд болно. Мөн ХХП ба УЗОБ-ын тухай тэдгээрийн удирдлагын үйл ажиллагааны тухай тайланг бэлтгэсэн байна. Уг тайланд тухайн асуудлууд ба ирээдүйн бэрхшээл зэрэг УЗОБ-ын асуудлаархи Стокгольмын Конвенцийн шаардлагыг биелүүлэхтэй холбогдсон асуудлуудыг нэмж тодорхойлсон. Одоо Европын хөршийн улсуудад ийм тайлан байхгүй байна. ДХХААБ Төв Азийн талаар ийм тогтоолыг 2009 онд нийтлэхээр төлөвлөж байна.

4.2. ЕХ-ны бус орнууд: Багахан ахиц

ЕХ-ны гишүүн бус орнуудад байдал янз бүр байсан ба байсаар байгаа бөгөөд энэ нь үндсэндээ Европын хөршийн улсуудын бодлогод нэгдсэн улсууд болон Зүүн Өмнөд Европын орнуудад юм. Үндэсний хууль тогтоомж сайн хөгжөөгүй, үйлдвэрлэгчид байхгүй болсон юмуу эсвэл тэд хариуцлагад татагдаж чадахгүй болсон, газар өмчлөлийн байдал төдий л тодорхой бус ба саармагжуулах ажлыг үр ашигтай явуулахад зориулагдсан дэд бүтэц үгүйтэй холбоотой бололтой. Хууль тогтоомжтой байсан ч тэр нь ихэвчлэн үйлчилдэггүй ба үндсэн шалтгаан нь ихэвчлэн улсаас гаргах хөрөнгө байдаггүйтэй холбоотой байдаг байна. Гэсэн ч зарим тодорхой арга хэмжээ Арктикийн бохирдлыг бууруулах Арктикийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөний (АЗАТ) хүрээнд арга хэмжээ хэрэгжиж, үүгээр бараг 2,000 тонн ХХП-ыг Оросын баруун хойд хэсэгт дахин савласан байна (АЗАТ, 2008). 2002 онд Албани улс, ЕХ ТЗЕОТХ-ийн хөтөлбөрөөс ХХП устгахад зориулж эдийн засгийн тусламж авчээ. Мөн Дэлхийн Банк 1,150 тонн УЗОБ, 1,060 тонн ПХБ, ПХБ-ээр бохирдсон хөрсийг цэвэрлэх ажлыг санаачлан Молдав улсад хэрэгжүүлэв (Плеска ба бусад, 2008). Энэхүү төсөл 2007 оны сүүлчээр хэрэгжиж дуусчээ. 2005-2008 онуудад Данийн Гадаад хэргийн яам нь Данийн сантай хамтран Молдав, Киргиз, Гүржэд⁸ ХХП-ийн эрсдлийг арилгах төслийг санхүүжүүлсэн байна. Дээр нь 2008 оны эцэс гэхэд чадавхтай болгох ба мэдээллийн асуудлыг дээшлүүлэх зорилгоор 400 гаруй тонн ХХП-ыг дахин савлаж аюулгүй хадгалалтад илгээсэн болно.

⁷ DANCEE Балтийн улсууд болон Орос (2000-2002); DANCEE, Латви,(2001); DANCEE (2002-2004); DANCEE Латви (1999-2004), DANCEE Литва (51995-2002); DANCEE (Зүүн ба Төв Европт)(2001); DANCEE (2003) ; DANCEE(1994-2001);DANCEE (2004-2006).

⁸ <http://milleukontakt.net/en/?p=480>

Сүүлийн үед мөн хөтөлбөрийн хүрээнд Украин улсад боломжийг бий болгох, дахин савлах арга хэмжээг хамтарсан шинэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл 2009 оны турш үргэлжлэн хэрэгжинэ. Данийн Засгийн газар 1999-2003 онд ХХП-ын талаархи тусгай хөтөлбөрийг дэмжиж 1,56 сая еврогийн төсөв олгож байв (DANCEE, 2003). Эхний үед Украин дах ХХП-ын агуулахуудаас үүдэх эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааны төлөвлөгөөний техникийн төлөвийг цаашид хэрэгжүүлэх шуурхай төслүүдийг боловсруулах асуудал байлаа. Хоёр дахь үе нь төслүүдийг шуурхай хэрэгжүүлэх, төсөл хэрэгжүүлж буй нутгийн байгууллагуудыг дэмжих, мөн олон нийтийн оролцоог дэмжих, судалгааны багийнхны сургалт явуулах ба дотоодын болон гадны санхүүгийн нөөцийг дайчлах явдал байв (WECF, 2006). Украинд 1,000 тонн ХХП-г зайлуулж, Германд устгах зорилгоор тээвэрлэлтийн шатандаа явж байна. Төслийг батлаж, хүрээлэн байгаа орчныг хамгаалах үндэсний сангаас санхүүжүүлсэн байна. Мөн дараачийн 2,000 тонн устгах тендер бэлтгэгдэж байгаа болно.

Гэвч эдгээр ажлууд нь нийт хийгдэх ёстой ажлын зөвхөн зарим хэсэг юм. Уг үйл ажиллагаанд оролцож байгаа бүх улсуудад уг асуудалд хандах системтэй хандлага байхгүйн зэрэгцээ эх үүсвэрүүдийг хамруулах боломжгүй байна. Гол асуудал HCH ба хортой ХХП-ын нөөцүүдэд байгаа юм. ЕХ-ны хүрээнээс гадна HCH-ны үндсэн нөөц нь хуучин Югославын Македон ба Азербайджан улсад байна. Эдгээр улсууд нь гол төлөв хууль эрх зүй, санхүү, бүтцийн дутмаг байдал ба мөн үйл ажиллагаа явуулах улс төрийн хүсэлгүй байж болох юм.

5. Урагшлахад зайлшгүй шаардагдах алхмууд

Ихэнхи улсууд өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлж, ХХП-ийг устгасан амжилтын тухай мэдээлэл олон бий. Ийм жишээ ЕХ-ны орнууд, бусад хөгжингүй улсууд, мөн ЕХ-ны шинэ гишүүн орнуудад байна. Эдгээр улсуудад мэдээллийн тогтолцоо, хууль тогтоомж, санхүүжилт болон техникийн мэдлэг бололцоо бүрдсэн юм. Эдгээр хүчин зүйлүүдийн зарим нь Европын хөршийн бодлогод нэгдсэн орнуудад байхгүй байна. Гэсэн ч эдгээр бүс нутгуудад тодорхой дэвшил илэрч байна. Бүс нутгийн анхны төсөл ДДБОС-ийн Зөвлөлөөр батлагдсан байна. ДХХААБ-ын нэрийн өмнөөс ОУГХЦГПХ ХП ба УЗОБ –ын чадавхийг бий болгох ДДБОС-ийн хөтөлбөрийг удирдаж, Дорнод Европын орнууд, Кавказ болон Төв Азид (ЕЕССА) болон хамтрагчид болох МиллеуCONTACT Интернэйшнл, Ногоон загалмай болон 9 орны төлөөлөгчидтэй хамтран пестицидийн асуудлаар хамтран ажиллахаар болж, хөтөлбөр 2009 оноос эхэлжээ. Хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл солилцоог дээшлүүлж, дараах 9 оронд чадавхи бий болгохоор тусгагдсан байна. Энд Албани, Армени, Азербайжан, Беларус, Гүрж, Македон, Монгол, Молдав, Румын зэрэг улсууд багтана. Энэхүү хөтөлбөрөөр бүс нутгийн хамтын ажиллагааг хүчтэй болгох, туршлага солилцох, тухайн бүс нутгийн аль нэг оронд цэвэрлэгээний үйл ажиллагааг явуулах зорилго тавьж байна.

Мөн энэ үед ХХП-тэй ажиллах НҮБ-ын мандат бүхий НҮБ-ын хүнсний хөтөлбөр Төв Ази, Өмнөд Кавказын орнуудад байдал ямар байгаа тухай тайланг нийтлэхээр төлөвлөж, тайлангийн үр дүнг анх удаа 2008 оны 12 сарын 2-4 өдрүүдэд Азербайжаны Бакуд зохиогдсон семинар дээр танилцуулсан юм. Зохион байгуулагч тал болох Азербайжаны Хөдөө аж ахуйн сайд байдал ноцтой байгааг тэмдэглээд уг ажилд бүгдийг даруй оролцохыг уриалсан болно. Одоо бусад бүс нутгийн талаархи санаачлагуудыг Дэлхийн банк дэмжин хэрэгжүүлж байгаа бөгөөд саяхан Гүрж, Киргизстан, Узбекистан, Таджикистанд тусгай төлөөлөгч илгээгээд байна.

Одоо бусад бүс нутгийн санаачлагуудыг Дэлхийн Банк дэмжин хэрэгжүүлж байгаа бөгөөд саяхан Гүрж, Киргизстан, Узбекистан, Таджикистанд тусгайлан даалгавар илгээгээд байна. Үүнээс гадна ДЭМБ-НҮБ-ЫН Хөгжлийн хөтөлбөр-МиллеуCONTACT Интернэйшнл, Ногоон Загалмайн гүйцэтгэсэн Кавказ, Төв Азийн ДДТ-д зориулсан ДДБОС-ийн бүс нутгийн төслийг тэмдэглэх хэрэгтэй. ДДТ-ийн талаархи төсөл нь энэ бүс нутагт хумхаа өвчний дэлгэрэлт гарч болзошгүй гэсэн таамаглал үүссэн үеэс хэрэгжиж эхэлсэн бөгөөд ДДТ-ийн нөөц устгах асуудлыг шийдвэрлэх тодорхой замыг хайж байгаа болно.

ДДБОС-ийн төслийн зэрэгцээ ОУГХЦГПХ-ны бүс нутгийн мэдээллийн ажлыг дээшлүүлэх, Виеслав Кучагийн сонгосон цэгүүд дэх ХХП-ийн нөхцөл байдлын дүрсэлсэн гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг хувийн санаачилгыг дэмжих ажил үргэлжлэх юм. Гэвч үүнээс ихийг хийх хэрэгтэй байгаа юм.

- Бүх орныг нэгэн зэрэг хамруулахын тулд ЕХ, магадгүй, бусад ивээн тэтгэгчидтэй хамтран мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ба тухайн нутгийн чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг санал болгож байна. Ийм хөтөлбөр ДДБОС–д бий бөгөөд харин түүний хамрах бүсийг өргөтгөж, түүнд сая хамрагдсан Албани, Армен, Азербайжан, Беларус, хуучин Югославын бүрэлдхүүний Македони, Гүрж, Молдав улс, Румын улсыг хязгаарлахгүй бүх 30 орныг хамруулах хэрэгтэй юм.

- Энэхүү үйл ажиллагааны зэрэгцээ ЕХ улс төрийн төвшинд одоогоор үүнийг хийгээгүй байгаа улсуудад Стокгольмын Конвенцийг батлахыг шаардах ёстой ба тухайлбал, Босни ба Герцеговин, Монтенегро, ОХУ, Серб, Турк улсуудад шаардах хэрэгтэй байна.

- Гурав дах алхам бол тооллогын бодит системийг байгуулах явдал мөн. Тооллогын систем нь төсвийг зохиох, бэлтгэх ба устгалын ажлыг явуулах цорын ганц үндэс болно. ЕХ-ны санхүүжүүлсэн хөтөлбөрөөр саяхан Румын улс бүх орныг хамарсан тооллогын системийг бэлтгэж эхэлжээ. Тооллого бол чадавхийг шаарддаг тул чадавхийг бий болгоход сургалтын хөтөлбөр хэрэгтэй болдог.

ДХХААБ ба НҮБ-ын бусад байгууллагуудад сургалтын хөтөлбөрт зориулсан материал бэлэн байгаа бөгөөд нийтийн хэрэгцээнд зориулагдсан хөтөлбөрийг бэлтгэж болох юм. Европын комисс нь Европын Холбооны болон бусад орнуудад сургалтын хөтөлбөр зохиох талаар ихээхэн туршлага хуримтлуулсан байна. ОУГХЦГПХ нь ХХП-ийн шинэ хуримтлал үүсэхээс урьдчилан сэргийлэх бодлого, стратегийг хөгжүүлэхэд Румынд туслалцаа үзүүлжээ. Энэ нь тодорхой орны төвшинд онц чухал ажил бөгөөд түүнийг ЕХ-ны орнуудад байгаа тэр хэлбэрээр нь хэрэгжүүлэхэд маш тохиромжтой бөгөөд энэхүү бодлого Европын болон үндэсний хууль тогтоомжуудад тусгагдсан байдаг. Саяхан Дэлхийн Банк ХХПестицидийн талаархи техникийн тайлан өгөх мэдэгдэл гаргахыг Киргизстан, Узбекстан, Таджикстанд санал болгосон ба түүндээ тооллого, эрсдлийн үнэлгээ, хадгалалтын үндэслэл, тээвэрлэлт, устгалын арга хэмжээний төлөв байдлыг тодорхой тусгах, гурван талбарт ХХП-ын устгал хийн, мөн түүн дээр нэмж хадгалах газар дээр нь арга хэмжээний бүх төрлөөр нутгийн мэргэжилтэн нарын сургалт явуулах, сонгомол цэвэрлэгээний техник-эдийн засгийн үндэслэл тусгасан байх хэрэгтэй ажээ. Энэхүү санаачлага 2009 оны сүүлээр эхлэж болох юм.

- ХХП-ын устгалын ажлын хамгийн өндөр үнэтэй хэсэг нь устгалд зориулсан нөөцийг гарган авах, хэрэв устгах боломжгүй байвал аюулгүй байдалд хадгалах явдал мөн. Орчин үед тусгай санаачлагуудыг зөвхөн Стокгольмын Конвенцийн хүрээнд нэмэн тусгасанаар тусламж хүргэх боломжтой байна. Тусгай санхүүжилт нь нөгөө талаас улсын хөрөнгө байгаа эсэх болон агуулах ба тооллогын мэдээлэл хэр зэрэг байгаагаас нэлээд хэмжээгээр хамаарагдана.

6. Санал болгож байгаа үйл ажиллагааны төлөвлөгөө

Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хэмжээний ХХП-ийн хуримтлал бүхий орнууд болон ХХП-ийн нөөцтэй орноос бүтээгдэхүүн авдаг орнуудад мэдлэгийн түвшинг өргөжүүлэх шаардлагатай юм. ХХП-ийн талаархи мэдээллийг цаашид сайжруулах ажлыг газар дээр нь тооллого явуулах ба үндэсний тайлан бэлтгэх замаар яаралтай гүйцэтгэх хэрэгтэй. Түүнээс гадна, хууль тогтоомжууд дахь дутуу тусгагдсан зүйлийг тодорхойлж, улс бүрт ХХП-г устгах үндэсний төлөвлөгөөг батлах, ХХП-ийн шинэ хуримтлал үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авах, шаардагдах санхүүжилтийн хэмжээг тодорхойлох хэрэгтэй байна.

Бид Европын комиссыг удирдан зохион байгуулах үүрэг хүлээж, Европын парламент, ЕХ-ны улсууд, мөн Европын хөршийн бодлогод нэгдсэн орнууд ба Төв Азийн улсууд, олон улсын байгууллагууд, тухайлбал ДХХААБ, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн Банк, Даян дэлхийн байгаль орчны сан, Хөдөө аж ахуйн байгууллагууд, ТББ, хэрэглэгчдийн байгууллага, үйлдвэрлэл, түүний дотор химийн үйлдвэрлэл болон бүтээгдэхүүн худалдаалагчидтай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах хэрэгтэй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь эдгээр байгууллагыг тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэх уриалга болох юм.

- Тэргүүлэгчдийн газрын удирдлагад байгаа зөвлөл нь өөрийн ажлын хэсэгт олон улсын экологийн асуудлаар ХХП-ийн талаар санал дэвшүүлэн тавина.

- Европын парламент нь:

- ХХП-ийн нөөцийн⁹ тухай тайланд пестицидийн талаар шаардагдах стратегид нэмэлт оруулахыг шаардах

- Шинээр бэлтгэгдэж байгаа хөршийн бодлогод ХХП-ийн асуудлыг онцлон тэмдэглэх

- ХХП-ийн нөөцтэй орнууд:

- Хүрээлэн байгаа орчны талаархи өөрийн үндэсний төлөвлөгөөнд ХХП-ийг устгах асуудлыг юуны урьд тусгах

- Ивээн тэтгэгчидтэй хийх хэлэлцээрийн хөтөлбөрт түүнийг устгах талаар оруулах

- Үндэсний санг хамтран бүрдүүлэх

- Европын Комисс, Европын парламент, Европын холбооны гишүүн орнууд асуудлын төвшин болон онцгой нөхцөл байдлын талаар загвар, боломжтой шийдлийг сайжруулах

- Шинэ ЕХ-ны гишүүн орнууд ХХП-ийн зах зээл, пестицидийн агуулахын чанарын талаар тайлан журмын дагуу яаралтайгаар хэрэгжүүлэх

- Ургамал хамгааллын холбоод үндэсний болон олон улсын бодлого боловсруулагчидтай хамтран “Хоосон контейнер хөтөлбөр”-ийг бий болгох, Франц, Польш улсуудын одоогийн ололт шиг ХХП-ийг цуглуулж устгах

⁹ Пестицидийн зохистой хэрэглээний Ажлын хүрээний зааварчилгааны хүрээнд хэлэлцэгдсэний дагуу

References

ACAP (Arctic Council Action Plan) (2008), Drafts Minutes ACAP Working Group, 4-5 March 2008, Moscow.

Anatov, Anatolii and Anatolii Gamera (2007), 9th international HCH and Pesticide Forum, 20-22 September 2007 (see http://www.ihpa.info/docs/library/9th/9thHCH_FORUM_BOOK_part1.pdf as well as part 2 and 3 on this website).

Barroso, Jose Manuel (2007), Contribution by the President of the European Commission, in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution, Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 96-106

BBC Radio 4, Broadcast on Problem of Accumulated Obsolete Pesticides in Africa (http://www.blackherbals.com/bbc_radio_4_broadcast_on.htm).

Brennpunkt LebensmittelSicherheit (2002), Nr. 1, p. 11, Juni, Der Nitrofen-Scandal, Behr's Verlag Hamburg.

CLU-IN 92008), Persistent Organic Pollutants-The Triple Price (video) (www.clu.in.org.ottawa).

Cramon-Taubadel, S. von (2002): Germany's Nitrofen Scandal and Food Safety in Ukraine. Beratungspapier S2 der Deutschen Beratergruppe Wirtschaft bei der ukrainischen Regierung. Kiev, Juli.

DANCEE (Danish Environmental Assistance to Eastern Europe) (1994-2001), Hazardous Waste Management Systems in Estonia, 124/009-0009, Danish EPA, DANCEE, Chemcontrol, 1991-4-2001.

DANCEE Lithuania (1995-2002), Action Plan for the Management of Un-used Pesticides in Lithuania, 124/025-0026, Danish EPA, DANCEE, by Krueger in collaboration with COWI.

DANCEE Latvia (1999-2002), Incinerator for Hazardous Waste in Latvia, 123/023-0070, Danish EPA, DANCEE, Chemcontrol.

DANCEE Baltic States and Russia (2001-2002), Project on the phase-out of POPs in the Baltic States and Russia, 124/000-0166 Danish EPA, DANCEE, COWI, 2001-2002.

DANCEE Eastern and Central Europe (2001), Review of OPS in Eastern and Central Europe, Elaborated COWI for the Danish EPA, Draft completion report, February 2001.

DANCEE Latvia (2001), Status on POPs Phase-out in the Baltic States (Latvia).

DANCEE (2002-2004), Elimination of Obsolete Pesticides, Latvia (2002-2004), COWI Consultants.

DANCEE (2003), Danish-Ukrainian Environmental Co-operation, 1993-2002.

DANCEE (2004-2006), Management of Obsolete Pesticides in the Russian Federation, COWI Consultants.

Danish EPA (2001-2004), Belarus, Survey, Management and Disposal of Accumulated, Obsolete Pesticides in Belarus, Danish EPA, DTI, COWI Consultants and DANCEM.

Dimas, Stavros (2007), "Danger of Obsolete Pesticides", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 108-114.

Dimcheva, Tsvetanka (2008), "Management of Obsolete Pesticides in Bulgaria", paper at Workshop on the management of polychlorinated biphenyl, OPs and unintentional emissions of persistent organic pollutants, Belgrade, 24-26 September 2008, INFRA 303731 (<http://taieux.ec.europa.eu/-see> TAIEX library).

ENS-News (2002), "Elbe Vulnerable as Czech Chemical Factory Floods" (<http://www.ens-news.com/ens/aug2002/2002-08-15-02.asp>).

Environment and Security (2007), Transforming risks into cooperation-the case of Eastern Europe, Transforming risks into cooperation. The case of Eastern Europe, Belarus-Moldova-Ukraine, UNEP, UNDP, UNECE, OSCE, REC, NATO.

European Commission (2002), Obsolete Pesticides Status in Candidate Countries, Final Report, September 2002, COWI for European Commission Directorate General for Environment.

European Commission (2007), Community Implementation Plan for the Stockholm Convention on Persistent Organic Pollutants, Staff Working Document, SEC(2007) 341 of 9.3.2007 (http://ec.europa.eu/environment/pops/index_en.htm).

Fedorov, Lev A. and Alexey V. Yablokov (2004), Pesticides: The chemical weapon that kills life (The USSR's tragic experience), PENSOFT Publishers, February.

Heinisch, Emmanuel (2007), "Hexachlorobenzene-imports via the River Elbe", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 334-342.

Holoubek, Ivan et al. (2006), The National Implementation Plans for Implementation of the Stockholm Convention in the Czech Republic, Project GF/CEN/01/003, Enabling Activities to Facilitate Early Action on the Implementation of the Stockholm Convention on Persistent Organic Pollutants (POPs) in the Czech Republic, Tocoen Report No. 23, p. 45, Brno, January.

Huebner, Danuta (2007), "Obsolete Pesticides", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 116-122.

Koppe, Jana G. and Jane Keys (2001), PCBs and the precautionary principle", in David Gee and Sofia Guedes Vaz, Late Lessons from Early warnings: The precautionary principle 1896-2000, Environmental Issue report No. 22, European Environment Agency, 2001.

Kuc, Wieslaw Stefan (ed.) (2007), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides.

Kuprianou, Markos (2007), "EU Measures for Pesticides in the Area of Health and Consumer Protection", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp 138-146.

Li, Yi Fan (1999), Global Technical Hexachlorocyclohexane Usage and Its Contamination Consequences for the Environment: from 1948 to 1997", Science of the Total Environment, Vol. 232, pp. 123-160.

Lithuanian National Implementation Plan (2007), "Persistent Organic Pollutants under the Stockholm Convention" (<http://www.pops.int/documents/implementation/nips/submissions/default.htm>).

Michel, Louis (2007), Risks of Obsolete Pesticides for Developing Countries", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 124-136.

National Implementation Policy of Ukraine (2007), Assessment and Development Strategy, Kyiv 2007, Ministry of Environmental Protection of Ukraine, p. 180, United Nations Development Programme, Global Environmental Facility, Kyiv.

Plesca, Valentin, Anatol Gobjila, Ion Barbarasa and Larisa Cupcea (2008), "POPs Stocks Management and Destruction in Moldova" in 9th International HCH and Pesticides Forum for CEECCA Countries, Chishinau, Moldova.

Umweltbundesamt (2007), Schadstoffkonzentrationen in Organismen der Nordsee, August (<http://www.umweltbundesamt-umweltdeutschland.de/umweltdaten/public/theme.do;jsessionid=80B4B76B28186A71978B399A197B1113?nodelfident=2416>).

UNECE (2004), Dniester cooperation to make drinking water safe (www.unece.org/press/pr2004/04env_p16e.htm).

UNEP (2000), Intergovernmental Negotiating Committee for an International Legally Binding Instrument for Implementing International Action on Certain Persistent Organic Pollutants, Fifth session, Johannesburg, 4-9 December, Item 3 of the provisional agenda (www.pops.int/documents/meetings/inc5/Fr/inf5-4/inf4.doc).

Vijgen, John (2006), The Legacy of Lindane HCH Isomer Production: A Global Overview of Residue Management, Formulation and Disposal, IHPA (<http://www.ihpa.info/docs/library/lindane%20Main%20Report%20DEF20JAN06.pdf>).

WECF (2006), Attention-Obsolete Pesticides!, The problem of OPs management in Ukraine, p.19 (http://www.wecf.de/english/publications/2006/obsolete_pesticides.php).

Wodageneh, Alemayehu (2007), "Complex Problems of Obsolete Pesticides and POPs", in Wieslaw Stefan Kuc (ed.), Caution! Dangerous Chemicals, Obsolete Pesticides, pp. 508-516.

Хавсралт 1. ХХП пестицид - улс орнуудын хэмжээ

Улс	Тоо хэмжээ /тонноор/	Тайлбар
Албани	0	2006 оны 4-р сараас Голланд улсын засгийн газрын санхүүжилтээр 353 тонн ХХП устгагдсан. 2001-2002 онд ЕХ-ны ТЗЕОТХ-ийн санхүүжилтээр 360 тонныг устгажээ.
Армени	800	
Азербайжан	4,000	
Беларус	6,558	ГХЦГ ба пестицидийн асуудлаархи олон улсын 9-р форум дээр мэдээлэгдсэн. 2007 оны 9-р сарын 20-22 өдрүүд.
Босниа Герцоговения	Тодорхойгүй	
Болгар	14,103	Болгарын Байгаль Орчин, Усны Яамны Татьяна Димчевагийн мэдээлснээр 2007 онд 14,103 тонноос 83.5% (11,773 тонн)-ийг шинээр баригдсан болон засварлагдсан улсын болон орон нутгийн 76 агуулахад аюулгүй хадгалалтад шилжүүлсэн ба 1,804 ББ-куб гэж нэрлэгдэх газарт хадгалжээ. Бусад 2.330 тонн нь түр хадгалагдаж буй ба байнгын хадгалалтын шийдэл байхгүй.
Хорват	0	
Чех улс	0	Байгаль Орчны Яамны мэдээгээр сүүлчийн 141 тонн ХХП 2007 онд устгажээ.
Эстони	0	Эстониин засгийн газрын мэдээгээр бүх 700 тонн хуримтлалыг 2007 онд зайлуулжээ.
Гүрж	3,000	
Унгар	200	2005-2006 онд 5 мужид 183 тонныг цуглуулж устгажээ. Үүнтэй адил үйл ажиллагааг зарим бүс нутагт төлөвлөсөн боловч санхүүгийн боломжоос хамаарч хойшлогдсон байна.
Казахстан	10,000	
Косово	8	
Киргиз	3,000	9-р сарын 20-22-ны өдрүүдэд Олон улсын ГХЦГ ба Пестицидийн форумын үеэр тайлагнажээ.
Латви	10	10 тонныг шинээр цуглуулж, 2,000 тонныг устгаад байна.
Литва	2,000	2002-2005 онд 3,190 тонн хуучирсан пестицид Герман руу устгуулахаар ачуулжээ.
Польш	5,000-7,000	2007 оны 9-р сарын 20-22-ны өдрүүдэд зохиогдсон Олон улсын ГХЦГ ба Пестицидийн 9 дэх форумын үеэр тайлагнажээ.

Улс орнууд	Тоо хэмжээ /тонноор/	Тайлбар
Молдав	5,450	Дэлхийн Банкны төслийн санхүүжилтээр 1,150 гаруй тонныг 2006-2007 онуудад устгажээ.
Румын	1,000	ЕХ-ны ТЗЕОТХ хөтөлбөрийн хүрээнд 2006 оны сүүлээр 2,300 гаруй тонныг устгажээ.
ОХУ	100,000	
Серб	200	2008 оны Үндэсний Хөтөлбөрт тусгагдсан.
Словак улс	300	
Словени	350-400	
Таджик	15,160	Таджикстаны Үндэсний Хөтөлбөр
Турк	3,000-3,300	Үндэсний Хөтөлбөрийн урьдчилсан төлөвлөгөө
Туркмени	1,671	Таамаг, тодорхой мэдээлэл байхгүй.
Украин	31,700	2007 оны Украины Үндэсний хөтөлбөр
Узбек	17,718	2005 оны 5-р сарын 26-28-ны өдрүүдэд зохиогдсон 8-р Олон улсын НСН ба Пестицидийн форум дээр тайлагнасан. Төрийн бус байгууллагын мэдээгээр 40,000 гаруй тонн байгаа.
Нийт	255,519- 262,572	

Эх үүсвэр: /UNEP/POPs/INC.5/: ОУГХЦГПХ төрөл бүрийн эх үүсвэрүүд дээр үндэслэн үнэлэв.

Хавсралт 2. ЕХолбооны улсуудын үйл ажиллагааны жишээнүүд

Литва улс одоогоор 2,000 тонн ХХП-ийг цуглуулан устгасан ба 6,215 м³ хөрс пестицидээр бохирдсон байна. 73% санхүүжилтийг Кохезион сангаас гаргасан ба 27% үндэсний сангаас санхүүжжээ. Литва 3,190 тонн хуучин пестицидийг Герман улс руу устгуулахаар ачуулсан нь тус улсын засгийн газрын 2002-2005 онуудад хэрэгжүүлсэн пестицидийн хаягдлын менежментийн хөтөлбөрийн нэг хэсэг юм /Литвийн үндэсний хэрэгжүүлэх хөтөлбөр, 2007/. Латви улс ХХП-ийн устгахад ТЗЕОТХ -ийн санхүүжилтийг ашигласан байна. Румын улс 2005-2006 онуудад ЕХ-ны ТЗЕОТХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2 жилийн хугацаанд 2,300 тонн пестицидийг устгасан байна. Гэсэн хэдий ч 500-1000 тонн пестицид тус оронд хадгалагдаж байна. ДАНСЕЕ хөтөлбөрийн хүрээнд Данийн засгийн газар Беларус, Латви, ОХУ-д ХХП-ийн асуудалд тусалсаар байна. Эстони улс нь ЕХ-ны ямар нэгэн санхүүгийн дэмжлэггүйгээр устгалын төсөвийг Эстони улсын өөрийн төсвөөс бүрдүүлж байна. 2001 онд 110,7 тонныг Финланд руу экспортлосон бол 2007 онд 103.9 тонныг Герман улс руу экспортложээ. ХХП-ийн үлдэгдэл хэсгийг Эстонид устгасан байна. Чех улс нь ХХП-ийг устгахад Хөдөө Аж Ахуйн Яам болон Улсын Ургамлын Эрүүл Ахуйн Албаны өөрийн сангаас санхүүжүүлжээ. 2007 оны мэдээнд дурдсанаар, 141 тонн ХХП-ийг дотооддоо устгасан байна.

Польш улс ХХП-ийн устгахад өөрийн улсын сангаас, Унгар улс мөн бага хэмжээний санхүүжилтийг устгалд зарцуулжээ. Бага хэмжээний тооллогын төслүүд Словак улс, Унгар улсуудад 2001 онд Данийн Байгаль Орчны Яамны дэмжлэгтэйгээр гүйцэтгэгдээд байна. Унгар улсад сүүлийн хэдэн жилд, пестицид цуглуулах ба савлах ажил эрхэлдэг улсын Цэбэр Кхт компани пестицидийг цуглуулж дахин савлах ажлыг хариуцаж, 183 тонн хугацаа нь дууссан пестицидийг цуглуулан устгажээ. Энэ үйл ажиллагаанд 80 сая унгар форинт зарцуулжээ (ойролцоогоор 330,000 евро). Цебер Кхт болон бусад эзэмшигчид пестицид цуглуулахад 15%-ийг, үлдсэн 85%-ийг хамааралтай яамдуудаас санхүүжилтийг гаргасан байна.

Үлдэгдэл 200 тонныг үргэлжлүүлэн устгахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг олох Цебер Кхт ба Рефлекс Ассоциацийн хүчин чармайлтыг эс тооцвол сүүлийн 3 жилд ямар нэг арга хэмжээг аваагүй юм.

1998-2007 онуудад Болгар улс ХХП-тэй хамааралтай үйл ажиллагаанд өөрийн нөөц (5,516 сая евро) ашигласан байна. 2007 онд нийт 14,103 тонн ХХП-ийн 83,5% (11,773 тонн)-г улсын болон орон нутгийн чанартай шинээр барьсан болон засварласан агуулахуудад байршуулж, мөн 1,804 ширхэг “ББ куб” гэж нэрлэгдэх 195x195x195 хэмжээтэй, 5 м³ ашигтай багтаамж бүхий хамгаалалтын шошготой төмөр бетонон саванд битүүмжилж хадгалжээ. Энэ нь тийм сайн шийдэл биш ч аюулыг түр хугацаагаар бууруулж байгаа оролдлого юм. Одоо тус улсад аюлгүйжүүлээгүй 2,330 тонн ХХП 358 агуулахад хадгалагдаж байна.

¹⁰ *Хатагтай Далиа Папивиене-мэдээ ISPA/Кохезион Төслийн Дэд Хэлтэсийн Эрхлэгч, Литва улсын Байгаль Орчны Яам, Байгаль Орчны Төслийн Менежментийн Агентлаг, INRA 2008 оны 10.21 хүлээн авсан.*

¹¹ *Данийн байгаль орчныг хамгаалах агентлаг, ДАНСЕЕ, 2004 10 сар.2.1.1 харах Дани болон Олон улсын Төв болон зүүн Европ дахь Стокгольмийн конвенцийн дэтжлээ (<http://www2.mst.dk/udgiv/publications/2005/87-7614-543-3/pdf/87-7614-544-1.pdf>)¹² Хатагтай Мари-Лис Уммикийн мэдээ, Эстони улсын Байгаль Орчны Яам, Хаягдлын Хэсгийн ахлах мэргэжилтэн, 2008 оны 10. 23 ОУГХЦГПХ хүлээн авсан.*

¹³ *Яромир Махарт, Чех улсын Хөдөө Аж Ахуйн Яам, 2008 оны 2 сар 20 ОУГХЦГПХ хүлээн авсан.*

¹⁴ *Тибор Ковач, Байгаль Орчны Рефлекс Ассоциация, 2008 10 сар 20 ОУГХЦГПХ хүлээн авсан.*

¹⁵ *Цетанка Димчевагийн ТАИЕХ семинар дээр танилцуулсан илтгэл Белград, 2008/ 09, Димчеваг харах*

Товчилсон нэрс:

АСАП/АСАР – Арктикийн Үйл Ажиллагааны Төлөвлөлтийн Зөвлөл
ЕХ - Европын Холбоо
DANCEE - Зүүн Европ дах Данийн Экологийн Тусламж
ТЗЕОТХ - Польш ба Унгар: Төв болон Зүүн Европын орнуудын туслалцааны хөтөлбөр
ДХХААБ – Дэлхийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
ДДБОС – Даян Дэлхийн Байгаль Орчны Сан
ЕХБ – Европын Хөршийн Бодлого
ҮХ – Үндэсний Хөтөлбөр
ДДТ - Дихлор-Дифенил-Трихлорэтан
ОУГХЦГПХ/ИНА - Олон улсын Гексахлорциклогексан ба Пестицидийн холбоо
НСВ – Гексахлорбензин
ГХЦГ – Гексахлорциклогексан/НСН
ТББ - Төрийн Бус Байгууллага
ХБОЧБ – Хөгжиж байгаа орнуудад чадавхийг бэхжүүлэх сан
УЗОБ – Удаан Задардаг Органик Бохирдуулагч
ХХП – Хэрэглээнээс хасагдсан пестицид
ЕПГ – Европын Парламентийн Гишүүн
РАН – Полиароматик Гидрокарбон
РСВ – Полихлорт Бифенил
ЮНИДО/UNIDO – НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
UNDP – Нэгдсэн Үндэстний Хөгжлийн Хөтөлбөр
CLU-IN- Нэгдсэн Улсын Хүрээлэн буй Орчны Агентлаг, Хортой Хаягдлын Цэвэрлэгээний Мэдээ
НҮБЕЭЗК – НҮБ-ын Европын эдийн засгийн комисс

Хэрэглээнээс хасагдсан үхэл дагуулах пестицидүүд

Эргэх тоолуур нь ажилласан тэсрэх бөмбөг ба яагаад бид одооноос хөдлөх тухай

Хэрэглээнээс хасагдсан пестицидийн хуримтлал нь зөвхөн нийгмийн эрүүл мэндэд аюул учруулаад зогсохгүй мөн байгалийн нөөцийг бохирдуулж нийгэм эдийн засгийн хөгжилд саад болно. Асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй аргуудыг бид хэдий чинээ хэр удаан хүлээнэ тэр хэмжээгээр асуудлын шийдвэрлэлт дараа нь төдий чинээ үнэтэй ба хүнд болно.

Дануга Хюбнер, Европын Холбооны бүс нутгийн асуудал эрхэлсэн комиссар (Хюбнер, 2007).

Хүнсний салбарт нитрофеноос болж гарсан шууд ба шууд бус хохирлыг Германы фермерүүдийн ассоциаци 500 сая еврогоос давсныг үнэлж байна.

(Brennpunkt LebensmittelSicherheit, 2002)

Энэхүү чухал асуудлыг шийдвэрлэх хамтарсан арга хэмжээг ойрын үед олон улсын төвшинд шийдвэртэй авч хэрэгжүүлэхгүй хойшлуулбал авах арга хэмжээ нь үр дүн багатай, оройтсон арга хэмжээ болно

Алемаеху Водагене, Хэрэглээнээс хасагдсан пестицидийн асуудлаархи ФАО-ийн хөтөлбөрийн зохицуулагч асан (Водагене, 2007)

Хэрэв юу ч хийхгүй бол нөөцийн ихэнхи нь эрт орой хэзээ нэгэн цагт хөрс, усны нөөц юмуу агаар мандалд орно. Хүрээлэн буй орчинд орсон тэдгээрийн хаягдлыг цэвэрлэхэд гарах зардал нэмэгдэх ба эрсдэл ихсэнэ. Комисс хэрэглээнээс хасагдсан пестицидийн асуудлыг шийдвэрлэх зорилго тавьж байна.

Ставрос Димас, Европын Холбооны Хүрээлэн Буй Орчны асуудал эрхэлсэн түшмэл (Димас, 2007).